

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	3
Өргөдөл, гомдол.....	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ	7
ХҮНИЙ НӨӨЦ.....	9
Бүтэц, зохион байгуулалт:.....	9
Гүйцэтгэсэн аудит:	10
Захиргааны ерөнхий хуулийн 103 дахь заалтын хэрэгжилт	11
Шинээр хэрэгжүүлсэн ажил.....	12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ.....	12
Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн.....	13
Санхүүгийн тайлангийн аудитын онцлог.....	13
Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	14
Завсрын аудитын талаар.....	14
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ.....	14
3.1. Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудит	15
3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудит:	16
3.3. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит:	17
3.4. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” -т хийсэн гүйцэтгэлийн аудит;	18
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ;.....	19
4.1. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах	19
4.2. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх	19
4.3. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудит	19
ТАВДУГААР БҮЛЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ	20
5.1. Баянхонгор аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн.....	20
5.2. Баянхонгор аймгийн орон нутгийн орлогод байгаль орчноос орж ирж байгаа хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүн /2020-2021/.....	20
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ.....	21
СУРГАЛТЫН ТАЛААР:	21
Хамтын ажиллагаа, олон нийт	22
Цахим системийн үйл ажиллагаа	24
Авлига, ашиг сонирхол, ёс зүй, ХАСХОМ:	24
Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт:.....	25
Архив, бичиг хэргийн хөтлөлт.....	25
Өргөдөл, гомдол.....	26
Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг утгасан арга хэмжээ	27
ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	27
НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	Error! Bookmark not defined.
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХАВСРАЛТУУД	Error! Bookmark not defined.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АГГ	Аудитын гуравдугаар газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АНУЗГ	Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газар
БНШК	Баримт нягтлан шалгах комисс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨХСЗ	Өмч хамгаалах салбар зөвлөл
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧБА	Чанарын баталгаажуулалтын алба

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.23

Баянхонгор хот

ХУРААНГУЙ ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 онд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 11 дүгээр зүйлийн 11.5, МУЕА-ын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/12 тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 4 аудит, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүсэлтээр гүйцэтгэлийн 2, хуулийн дагуу гүйцэтгэлийн 1, нийцлийн аудит 3 нийтдээ шууд тайлагнах 10, санхүүгийн тайлангийн аудитад 264 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Хүний нөөц

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 оны эхний хагас жилээс хойш 10 орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд тайлант онд дунджаар 11 хүн 20648 хүн/цаг ажиллахаас 22706 хүн/цаг буюу 2058 хүн/цаг илүү ажиллан дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэв.

Тайлан оны эцэст нийт 12 орон тооноос аудитор (эрх зүйч)-1, аудитор (нягтлан бодогчийн үүргийг хэрэгжүүлэгч)-1 орон тоо тус тус сул байгаа сул орон тоог нөхөх зарыг олон нийтэд зарласан.

Аудитын дүн

- Санхүүгийн тайлангийн аудитад 264 хамрагдсанаас 132 байгууллагад Төрийн аудитын газар, 40 байгууллагад хувийн аудитын хуулийн этгээд аудит хийн дүгнэлт гаргаж, 92 байгууллагыг түүвэрт хамруулсан. Дүгнэлт гаргасан 172 байгууллагаас 148 байгууллагад “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.
- 2022 онд хийсэн санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар нийт 41,836.0 сая төгрөгийн 1,015 алдаа, зөрчил илэрч, 790.9 сая төгрөгийн 131 төлбөрийн акт тогтоосноос 690.9 сая (87.4%), зөрчлийг арилгах 10,175.3 сая төгрөгийн 203 албан шаардлага хүргүүлснээс 9,457.6 сая (92.9%), зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 29,174.7 сая төгрөгийн 557 заалт бүхий зөвлөмж өгснөөс 24,732.7 сая (84.8%) төгрөгийн зөрчлийг тус тус арилгаж, 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Хүснэгт: 1. Илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

/сая.төг/

Үзүүлэлт	Тогтоосон		Хэрэгжсэн		Хувь
	Тоо	дүн	Тоо	дүн	
Төлбөрийн акт	131	790.9	118	690.9	87.4
Албан шаардлага	203	10,175.3	187	9,457.6	92.9
Зөвлөмж	557	29,174.7	492	24,732.7	84.8
залруулга	119	1,695.1	119	1,695.1	100.0
Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	5	-	5	-	100.0
Нийт дүн	1015	41,836.0	916	36,576.3	91.3

Эх сурвалж: ТАГ-ын 2022 оны статистик мэдээ

Хугацаа болоогүй шийдвэрийн хэрэгжилтийг хасаж тооцвол төлбөрийн актын 88.5%, албан шаардлагын 93.3%, зөвлөмжийн 99.8% биелэлттэй гарч байна.

Сургалт

Төрийн аудитын байгууллагын 2022 онд дэвшүүлсэн "Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах" зорилтын ТАБ-аас болон байгууллагын дотоод сургалтаар 5 чиглэлээр 26 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан Газрын дарга, тэргүүлэх аудитораар 2022.01.25-ны өдөр батлуулж хэрэгжилтийг сургалтын хяналтын самбар дээр хугацаагаар нь хэрэгжилтийг тооцон ажиллав.

ТАБ-ын нэгдсэн сургалтын болон байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан 5 зорилтын хүрээнд 44 удаагийн сургалт, хэлэлцүүлгээр 549 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Үүнд:

- ҮАГ-аас зохион байгуулсан 24 сургалтад давхардсан тоогоор 196 албан хаагч
- Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 сургалтад давхардсан тоогоор 333 албан хаагч (Төрийн аудитын газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан Төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудыг оруулан тооцсон тоо)
- Бусад байгууллагаас зохион байгуулсан 8 сургалтад 20 албан хаагч тус тус оролцсон байна.

Мэдээлэл сурталчилгаа

Тайлант хугацаанд хэвлэмэл болон хувилж өгсөн тайлан 284, хэвлэлийн мэдээ, нийтлэл 75, Радио, телевизийн мэдээ, нэвтрүүлэг 4, бусад байгууллагад хийсэн мэдээлэл, сурталчилгаа 12 бүгд нийт 375 мэдээлэл сурталчилгаа хийсэн байна.

Санхүү, гүйцэтгэл, нийлцийн аудитын 8 тайланг инфографик цахим ном /визуал/ хэлбэрээр audit.mn болон facebook пэйж хуудсаар, Төрийн аудитын байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон цаг үеийн ажилтай холбоотой 144 мэдээллийг тухай бүр олон нийтийн сүлжээгээр хүргэн ажилласан. Төрийн аудитын байгууллагын 100 жилийн түүх ой хүрээнд хийгдсэн нэвтрүүлэг, танилцуулгыг олон нийтийн сүлжээнд facebook пэйж хуудсаар болон олон нийтийн дүрст самбараар мэдээлсэн.

Төрийн аудитын газрын үйл ажиллагааг сурталчлах, аудитын дүн дүгнэлтийг олон нийтэд хүргэхээр “Өнөөгийн Баянхонгор” сонин, “Номгон ТВ” зэрэг орон нутгийн хэвлэлийн байгууллагуудтай гэрээ байгуулан Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл аудитын 4 мэдээллийг нийтлүүлж, нэвтрүүлсэн.

Төрийн аудитын цахим хуудас болох audit.mn, tailan.audit.mn, open.audit.mn болон олон нийтийн сүлжээ зэрэг цахим сайтуудаар давхардсан тоогоор 543 мэдээлэл байршуулсан.

Өргөдөл, гомдол

Тайлант онд албан хаагчдаас ажлаас чөлөөлөгдөх 3, чөлөө хүссэн 1, иргэдээс сул ажлын байранд орох хүсэлтэй 5 өргөдөл ирснийг МУЕА-т уламжилж хугацаанд нь шийдвэрлүүлж хариуг нь холбогдох хүмүүст өгсөн.

Дэвшүүлсэн зорилтын биелэлт

МУЕА-ын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2022 оны зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын газраар хянуулан 3 арга хэмжээг хэрэгжүүлэх Газрын даргаар 2022.02.24-ны өдөр батлуулсан бөгөөд МУЕА-ын 2022.04.18-ны өдрийн А/35 дугаар тушаалаар 2 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу дэд төлөвлөгөөндөө нэмэлт оруулан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар зорилтыг хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөөг боловсруулан дараах 5 арга хэмжээтэй байхаар тусгасан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр нөлөө, үр дүн сэдэвт аудитын тайланг Ажлын хэсгийн хурлаар оруулах

2. “Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт
3. ҮАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах
4. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газартай хамтран Чанарын хяналтын сайн туршлагыг харуулсан үзүүлэх сургалт, хэлэлцүүлэг хийх.
5. Шууд тайлагнах болон нотлох ажилд хамаарах аудитын түвшинд үнэлгээ хийж, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлагнах (Архангай аймагтай хамтран)

Жилийн зорилтын хэрэгжилтийг ҮАГ-ын АНУЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2022.06.02-оос сараас эхлэн нийт 10 удаа тайлагнасан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг 2022.12.07-нд ҮАГ-ын ЧБА-нд тайлагнасан.

Үр өгөөж

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/82 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Аудитын үр өгөөжийн журам"-ын дагуу тайлант онд гүйцэтгэсэн нотлох аудитаас 5,196.1 сая төгрөгийн 159, шууд тайлагнах аудитаас 7,385.2 сая төгрөгийн 43, төсвийн төсөлд дүгнэлт өгөх дүн шинжилгээний аудитаас 9,257.0 сая төгрөгийн 3, нийтдээ 21,838.3 сая төгрөгийн 203 санхүүгийн, 2 санхүүгийн бус үр өгөөжийг тооцсоныг орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрсөн.

Тайлант онд нийт 479.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд 2022.12.23-ны байдлаар 462.3 сая төгрөгийг зарцуулж зардлын 1 төгрөг тутмаас 47.24 төгрөгийн үр өгөөж гарч өмнөх оны мөн үеэс 73.0 хувиар буюу 19.93 төгрөгөөр нэмэгдүүлэн ажиллалаа.

Аудитын үр дүнгээс үзвэл аудитаар тогтоосон 131 төлбөрийн актаас 790.9 сая, зөрчил арилгахаар өгсөн 48 албан шаардлагыг биелүүлснээр 5,589.3 сая, хөрөнгийн үр нөлөө үр ашгийг дээшлүүлэх 15 заалт бүхий зөвлөмжийг биелүүлснээр 6,136.8 сая, санхүүгийн тайланд хүлээн аваагүй хөрөнгийг бүртгэснийг залруулж авлагыг барагдуулах 11 зөрчлийг арилгаснаар 9,321.3 сая, төсвийн хөрөнгийн орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулж, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх дүгнэлт гаргаснаар 9,321.3 сая төгрөгийн 3 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж тооцлоо.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар дараах ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.



Аудитын чанар, хяналтын үр нөлөөг сайжруулах дэд ажлын төлөвлөгөөг боловсруулан ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын газраар хянуулан 3 арга хэмжээг хэрэгжүүлэх Газрын даргаар 2022.02.24-ны өдөр батлуулсан бөгөөд Тус төлөвлөгөөнд МУЕА-ын 2022.04.18-ны өдрийн А/35 дугаар тушаалаар 2 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр дэд төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулан хэрэгжилтийг ҮАГ-ын ХБТГ, АНУЗГ, СНАГ, ГНАГ, ЧБА-аас зөвлөмж, чиглэл авч, Архангай болон Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газруудтай хамтран зохион байгуулж хэрэгжилтийг хангасан.



Дотоод сургалтын төлөвлөгөөний чанарын хяналтын талаар сургалт хийх, ЧБА-аас түншийн үнэлгээний талаар сургалт авах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд дотоод сургалтаараа Аудитын менежер “Ахлах аудитор аудитын чанарын хяналт хийх”, ҮАГ-ын АНУГ-аас “Чанарын тогтолцоо”, ҮАГ-ын ЧБА-аас “Чанарын баталгаажуулалтын түншийн үнэлгээ” сэдвээр тус тус авч ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх мэдээлэл сургалтад хамруулан ажилласан.



ҮАГ-аас зохион байгуулсан нэгдсэн сургалтад нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх ОНХС-ын аудитын төлөвлөлтийг танилцуулан гүйцэтгэл, тайлагналын шатанд чанарын талаар анхаарах асуудлаар хэлэлцүүлгийг 5 удаа хийсэн. Энэ нь аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас сайн туршлага судалсан өгөөжтэй арга хэмжээ болсон.

Байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 стратеги зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан Монгол улсын ерөнхий аудиторын орлогчийн тэргүүлэх аудитор Я.Сарансүх даргаар 2022.04.05-нд батлуулан ажиллахын зэрэгцээ дараах дэд төлөвлөгөөнүүдийг дотоодоо батлан хэрэгжилтийг бүрэн хангаж ҮАГ-ын ЗББН-үүдэд биелэлтийн тайланг 2022.12.15-16-нд хүргүүлэн ажиллав.



Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөө



Харилцагч талуудын оролцооны дэд төлөвлөгөө



Байгууллагын баримт бичиг, нягтлан шалгах комисс болон өмч хамгаалах салбар зөвлөлийн 2022 онд хийх ажлын төлөвлөгөө



“Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ын 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө

ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Төрийн аудитын байгууллагын 2022 оны “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар ажлын дэд төлөвлөгөө боловсруулан дараах 5 арга хэмжээг тусгасан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр нөлөө, үр дүн сэдэвт аудитын тайланг Ажлын хэсгийн хурлаар оруулах:

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын нэгдсэн тайлангийн төслийг аудитын хөтөлбөрт заасан хугацаанд буюу 2022.07.01-ны өдрийн 1/402 тоот албан бичгээр ҮАГ-ын АНГ-т хүргүүлсэн.

Аудитын тайланг МУЕА-ын орлогч, тэргүүлэх аудитор Я.Сарансүх чанарын хяналтыг хэрэгжүүлэн ирүүлсэн арга зүй, хяналтын хуудасны дагуу тайланд засварыг хийж тухай бүр нь хүргүүлэн нэгдсэн тайланг ҮАГ-ын Удирдлагын зөвлөл хуралд 2022.11.01-ны өдөр танхимаар (АНТАГ-ын цахимаар оролцон) оруулсан. УЗ-ийн хурлаар гишүүдээс өгсөн нэмэлт гүйцэтгэх судалгааг АНТАГ-аас авч бэлтгэн тайланд нэмж тусган холбогдох өөрчлөлт, засвар хийу ҮАГ-ын ЧБА-аар чанарын хяналт хийлгэн МУЕА-ын 2022 оны 12 дугаарын сарын 09-ний өдрийн А/91 тоот тушаалаар аудитын тайланг батлуулсан.

Үр дүн: Орон нутаг дахь Төрийн аудитын газар анх удаа Нэгдсэн удирдамжтай аудитыг удирдан, аудитын үе шатанд нэгдсэн сургалтыг зохион байгуулан чанарын хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэж байгаа нь аудиторуудын үр чадварыг нэмэгдүүлсэн, харилцаа хандлага сайжирч, бие биеэсээ суралцах боломж бүрдэж, цаашид судалгааны маягыг ОНХС-гийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхдээ ашигласнаар хянан удирдах ажилтнуудын чанарыг хяналтыг шинэ түвшин гаргаж, аудитаас гарах үр нөлөө дээшилсэн.

“Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт:

ҮАГ-ын АНУЗГ-аас 2022.06.22-ны өдөр АНТАГ-ын ажилтнуудыг хамруулан цахим сургалт зохион байгуулж ажилтнууд бүрэн оролцлоо. Сургалтыг аудитын менежер Ж.Батсайхан хийж, хэлэлцүүлгийн үед аймгийн ТАГ-ын аудиторууд асуулт асууж, харилцан ярилцаж оролцов. Тус сургалтаас болон ОНХС-ийн аудитын хүрээнд хэрэгжүүлсэн чанарын хяналтын туршлагад тулгуурлан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын нэгж 7 хоног бүрийн Баасан гарагт гүйцэтгэж буй аудитын талаар багаар ярилцаж, ахлах аудитор хяналт тавьж ажиллах арга барилыг 2022 оны 9 дүгээр сараас эхлэн туршин нэвтрүүлсэн.

Үр дүн: Багийн ахлагчаас хийх чанарын хяналтыг давтамжтайгаар хийснээр аудитыг хянан удирдаж байгаа албан хаагчид аудитын явцын талаар мэдээлэл авч, үүрэг даалгавар өгч, аудитын чанар сайжирсан.

ҮАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах:

Түншийн үнэлгээний талаар сургалт авах хүсэлтийг ҮАГ-ын ЧБА-д саналыг хүргүүлж төлөвлөгөөнд тусгуулсан ба тухайн сургалтыг 6 дугаар сард багтаан авах хүсэлтийг 2022.06.09-ны өдрийн 1/367 тоот албан бичгээр уламжилсан.

Үндэсний аудитын газар НҮБХХ-тэй хамтран улс орнуудын аудитын дээд байгууллагууд аудитын чанарыг тогтмол өндөр түвшинд байлгахын тулд хэрэгжүүлдэг чанарын баталгаажуулалт, хяналт, шалгалтын талаарх мэдлэг, туршлагыг хуваалцах зорилгоор “Чанарын баталгаа ба хяналт” онлайн семинарт 2022.06.29-ны өдөр дарга, аудитын менежер нар оролцлоо.

Дээрх хүсэлтийн дагуу Чанарын баталгаажуулалтын алба "Аудитын чанарын удирдлага, үр нөлөө" сэдэвт танилцуулга, хэлэлцүүлгийн онлайн сургалтад 2022.09.20-ны өдөр зохион байгуулж Баянхонгор, Дорнод, Дорноговь, Говь-Алтай, Завхан, Дархан аймгуудын ТАГ-ын албан хаагчид оролцож, сургалтаар, ТАГ-ын албан хаагчид сонирхсон асуудалд Чанарын баталгаажуулалтын албаны дарга С.Оюунгэрэл хариулт өгч харилцан ярилцаж, санал бодлоо солилцов.

Үр дүн: АНТАГ-ууд нээгдсэн нэг ойлголтын дагуу аудитыг гүйцэтгэх, цаг хугацаандаа аудитыг хийх, баталгаажуулахын ач холбогдол, харилцан туршлага судлах боломж бүрдсэн.

Говь-Алтай, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар хамтран Чанарын хяналтын сайн туршлагыг харуулсан үзүүлэх сургалт, хэлэлцүүлэг хийх:

Тус 4 дэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говь-Алтай аймагт 2022.10.24-нд, Баянхонгор аймагт 2022.11.11-ны өдөр ТАГ-уудын 2022 онд гүйцэтгэсэн нотлох ажил 6, шууд тайлагнах 1 ажилд хамаарах аудитын түвшинд хийсэн тайлангууд, хадгаламжийн нэгж архивын баримттай танилцан, харилцан аудитын түвшинд үнэлгээ хийж, аудиторуд чанарын хяналтын сайн туршлагыг ярилцан, байгууллагуудын ажлын туршлагатай газар дээр нь танилцан, аймаг бүрд хэлэлцүүлэг зохион байгуулан харилцан туршлагаа солилцож үр дүнгээ тооцож ажиллав.

Үр дүн: Говь-Алтай, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд аудитын ажлын үе шатны ажлын гүйцэтгэл, чанарын хяналтын сайн туршлагыг ажлын байран дээр аймаг бүрд 6 ажилтан очиж судалж, хэлэлцүүлэгт 21 албан хаагчид оролцсоноор өөрийн аймагт байгаа ололттой тал, анхаарах асуудлыг сонсож, харилцан аймгийнхаа сайн туршлагыг ажилдаа нэвтрүүлэх талаар харилцан ярилцаж аудиторудад мэдлэг, ажлын туршлага нэмэгдсэн.

Шууд тайлагнах болон нотлох ажилд хамаарах аудитын түвшинд үнэлгээ хийж, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлагнах /Архангай аймгийн ТАГ-тай хамтран/

Тус 5 дах арга хэмжээний хүрээнд Баянхонгор, Архангай аймгийн Төрийн аудитын газрын шууд тайлагнах болон нотлох ажилд хамаарах аудитын түвшинд үнэлгээ хийж байгаа байдалтай 2022.09.22-23-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн ажилтай танилцан, хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллав. Тус ажлын хүрээнд 2 аймгийн аудиторуд харилцан санхүүгийн аудитын 3, нотлох ажлын 1 аудитын иж бүрэн баримтыг аймаг бүр харилцан солилцон аудитын түвшинд үнэлгээ хийж, Баянхонгор аймаг дахь ТАГ удирдан хэлэлцүүлэг зохион байгуулж, 19 албан хаагч оролцон сайн туршлага, ололттой тал болон анхаарах асуудлыг нээлттэй ярилцаж хурлын тэмдэглэл хөтлөн, тайлан бичиж харилцан баталгаажууллаа.

Архангай аймгийн Төрийн аудитын газрын аудитад чанарын хяналт хийж байгаа байдал, хадгаламжийн нэгжийн бүрдүүлэлт, ажлын баримтын бүрдэл дэх ололттой асуудлуудыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, сайн туршлагыг хэрэгжүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн ба мөн Архангай аймаг сайн туршлагыг ажилдаа нэвтрүүлж ажиллахаа хурлын үеэр илэрхийлсэн.

Үр дүн: Аудитын чанар хяналтын үр нөлөө дээшлэн, аудитын илрүүлэлт нэмэгдэж, аудиторын гүйцэтгэсэн горим, сорилын үр дүн тодорхой тайлагнагдаж, шийдвэрийн хэрэгжилтийн хувь өсөж, аудитын түвшинд хийсэн түншийн үнэлгээний үр дүн гарсан.

ХҮНИЙ НӨӨЦ

Тайлант онд нийт хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, дүрэм журмыг мөрдөн ажиллав.



МУЕА-ын 2021 оны А/126 тушаалаар батлагдсан Аймаг дахь Төрийн аудитын газрын албан тушаалын тодорхойлолтыг хэрэгжүүлж ажиллах Тамгын даргаас өгсөн чиглэлийн дагуу гэрээтээр ажилласан байсан бичиг хэргийн ажилтны гэрээг 2022.03.15-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлсөн.




МУЕА-ын 2021 оны А/19 тоот тушаалаар Баянхонгор аймаг дахь 12 орон тоогоор 2022.07.18-н хүртэл бүрэн ажилласан. Харин 2022 оны 07-р сард 2 аудитор (архив, бичиг хэргийн үүргийг хэрэгжүүлэгч болон эрх зүйч), 2022 оны 11-р сард 1 аудитор (нягтлан бодогчийн үүргийг хэрэгжүүлэгч) тус тус өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.



Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог нөхөн зарыг 2022 оны 09-р сард 2 ажлын байрны зар нийтэд түгээж ҮАГ-аас 2022 оны 11-р сард зохион байгуулагдсан сонгон шалгаруулалтаар нэг орон тоо нөхөгдсөн. 2022.12-р сард 2 орон тоог нөхөх зарыг олон нийтэд түгээж 5 хүний материал ирснийг сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оруулахаар 2022.12.21-нд МУЕА-т уламжилсан.

2022 оны гүйцэтгэлийн зорилтод ажлаа үндсэн 11 (дунджаар) ажилтантайгаар 20,648 хүн/цаг ажиллахаас 22,706 хүн/цаг буюу 2,058 хүн/цаг илүү ажиллан бүрэн хэрэгжүүлэв.



Бүтэц, зохион байгуулалт:

Монгол улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/02 тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.



Нотлох аудитад 2 аудитор, шууд тайлагнах аудитад 7 аудитор, ажлын ачааллаас шалтгаалан шууд тайлагнах аудитын аудиторууд хоорондоо шилжин ажиллах нь хэвээрээ байхаар зохион байгуулалтыг хийж ажиллалаа.



Тус аудитын газар нь 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, МУЕА-аас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэхэд өдөр тутмын ажлаа чиглүүлэн Удирдлагын ABLE системийн “АЖИЛ ХЭРЭГ” цэсийг ашиглан 7 хоногоор хийх ажлын төлөвлөгөө болон үүрэг даалгаврын биелэлтэд нийт ажилтны шуурхай хурлаар хэлэлцэх байдлаар хяналт тавин удирдан зохион байгуулж ажилласан. Тайлант оны дүнгээр нийт 380 ажлыг өдөр тутам нэмж гүйцэтгэхээр оруулж хэрэгжилтийг хангасан байна.

Гүйцэтгэсэн аудит:



Тайлант 2022 онд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.8-д заасан хугацаанд нийт 264 байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд аудит хийснээс 92 байгууллагад түүвэр, 172 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, үүнээс 148 байгууллага “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна.



Сөрөг дүгнэлт авсан 1 байгууллагын удирдлагад “Төрийн аудитын тухай хууль”-ийн 42 дугаар зүйлийн 42.1-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг хүргүүлэх хуулийн заалттай боловч “Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээ алба” УТҮГ-ын дарга нь ажлаас чөлөөлөгдсөн ажлыг тул эрх бүхий албан тушаалтанд саналыг хүргүүлээгүй болно.



ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 4 аудит, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүсэлтээр гүйцэтгэлийн 2, хуулийн дагуу гүйцэтгэлийн 1, нийцлийн аудит 3 нийтдээ шууд тайлагнах 10, үүнээс гүйцэтгэлийн 7 аудит, нийцлийн аудит 3-ыг тус тус гүйцэтгэж, тайлан, судалгааг хугацаанд нь холбогдох газруудад албан тоотоор хүргүүлсэн.

Шийдвэрийн хэрэгжилт

91.3%



2022 онд хийсэн санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар нийт 41,836.0 сая төгрөгийн 1,015 алдаа, зөрчил илэрч, 790.9 сая төгрөгийн 131 төлбөрийн акт тогтоосноос 690.9 сая (87.4%), зөрчлийг арилгах 10,175.3 сая төгрөгийн 203 албан шаардлага хүргүүлснээс 9,457.6 сая (92.9%), зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 29,174.7 сая төгрөгийн 557 заалт бүхий зөвлөмж өгснөөс 24,732.7 сая (84.8%) төгрөгийн зөрчлийг тус тус арилгаж, 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Тайлант онд гүйцэтгэсэн аудитаас нийтдээ 21,838.3 сая төгрөгийн үр өгөөж тооцсоныг орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрсөн ба зардлын 1 төгрөг тутмаас 47.24 төгрөгийн үр өгөөж гарч өмнөх оны мөн үеэс 73.0 хувиар буюу 19.93 төгрөгөөр нэмэгдүүлэн ажиллалаа.



Хугацаа хэтэрсэн !!!

Аудитаар хууль, тогтоомж зөрчсөн буруутай 5 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг хангуулсан.

2022 оны эцэст нийт 5,259.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас 4,431.2 сая төгрөгийн шийдвэрийн хэрэгжилтийн хугацаа болоогүй, 1,096.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн дүнтэй байна.

Хугацаа болоогүй шийдвэрийг хасаж тооцоход

Төлбөрийн актын 88.5 %, албан шаардлагын 93.3%, зөвлөмжийн 99.8% биелэлттэй гарч байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дахь заалтын хэрэгжилт



Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, 103.3 дахь хэсэгт заасны асуудлуудаар 2018 оноос хойш зөрчлийн сан үүсгэж нэгдсэн бүртгэл хөтөлж байгаа бөгөөд 2022 онд буруутай 6 албан тушаалтны шийдвэрээр төрд учирсан 30.2 сая төгрөгийн хохирлын мэдээллийг нэмж бүртгэн үүнээс 1 албан тушаалтнаар 0.7 сая төгрөгийг төсөвт төлүүлсэн ба мэдээллийн санг googledrive программын ашиглан дундын файл үүсгэн ашиглаж байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх даргад 2022.04.05-ны өдрийн 1/286 тоот албан бичгээр Төрд учирсан хохирлын талаарх судалгааг хүргүүлэн тайлагнаж ажилласан.



Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба болон холбогдох Төрийн үйлчилгээний байгууллагын удирдлагад хүргүүлж төлбөр барагдуулах хуваарь гарган ажилласан.

Шинээр хэрэгжүүлсэн ажил

ҮАГ-ын МТТ-өөс нэвтрүүлж байгаа аудитыг цахимжуулах ажлын манлайлан хэрэгжүүлэхийг зорин ажилласны дүнд Санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системийг 2022 оны санхүүгийн аудитад бүрэн нэвтрүүлж, 2022.10-р сард хийсэн хөгжүүлэлтээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүртгэх, биелэлтийг тооцох системд мэдээллийг оруулан ажилласан. Мөн гүйцэтгэлийн аудитын perf.audit.mn системийг нэвтрүүлэх туршилтын ажилд оролцож байна. аудиторуд дээрх программыг бүрэн ашигласнаар ажлын цаг ашиглалт, аудитын үр нөлөө, үр дүнг сайжруулж мэдээллийн үнэн зөв алдаагүй бэлтгэх, нэгтгэх боломж бүрдүүлсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/87 дугаар тушаалыг үндэслэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн хэмжээнд 161 төсөвт байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч 1, улсын төсвийн 32 нийт 264 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 172 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 92 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан



Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг, Баян-Овоо сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн ч тус байгууллагууд нь санхүүгийн тайлан, аудит хийлгэх хүсэлтийг ирүүлээгүй тул аудитад хамрагдаагүй болно.



Аудитад хамрагдаж санал дүгнэлт өгсөн 172 байгууллагын 148 байгууллагад “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн.



Санхүүгийн тайлангийн аудитын 84.8 хувийг буюу 224 байгууллагыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар өөрсдийн хүчээр гүйцэтгэж, 15.2 хувь буюу 40 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Баян ташаагийн эх аудит” ХХК 20 байгууллагад, “Глобал капитал аудит” ХХК компани 20 байгууллагатай гэрээ байгуулж, аудитыг гүйцэтгэсэн байна.



Аудитад Төрийн аудитын байгууллагын үндсэн 9 аудитор, хараат бус аудитын 2 компанийн 6 аудитор гүйцэтгэн, үе шатны хяналтыг аудитын менежер хяналт тавьж, газрын дарга, тэргүүлэх аудитор хянан удирдан 219.9 сая төгрөгийн өртгөөр нийт 11 хүн 180 өдөр, 1166 хүн/өдөр, 1454 илүү цаг ажиллан 5,196.1 сая төгрөгийн 157 санхүүгийн, 2 санхүүгийн бус үр өгөөж хүлээн зөвшөөрөн ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

- Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,973.8 сая төгрөгийн 834 алдаа зөрчил илэрснээс 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжээгүй үлдэгдэлтэй байсан 37.7 сая төгрөгийн 5 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 249.1 сая төгрөгийн 14 албан шаардлагаас 182.1 сая төгрөгийн 6 албан шаардлагын зөрчлийн арилгаж, 12.2 сая төгрөгийн 1 зөвлөмж хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаагаас шалтгаалж бүрэн хэрэгжээгүй байна.
- Аудитаар 20,278.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд 689.0 сая төгрөгийн 120 төлбөрийн акт, 3,915.8 сая төгрөгийн зөрчилд 123 албан шаардлага, 15,673.9 сая төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 472 зөвлөмжийг хүргүүлж ажиллав.
- Залруулагдаагүй зөрчлийг авч үзэхэд Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчил 64 хувь, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил 16 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 8 хувь, бусад үйл ажиллагаатай холбоотой зөрчил 12 хувийг эзэлж байна.
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын 89% буюу 612.5 сая, албан шаардлагын 98% буюу 3,819.5 сая төгрөгийг барагдуулж, зөвлөмжийн 98% буюу 15,285.2 сая төгрөгийн хэрэгжилтийг шалгагдагч байгууллага гаргаж ирүүлснийг нотлох баримтад үндэслэн тооцов.




Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дугаар "Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар "Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл", хоёр дугаар хавсралтаар "Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж"-ийг санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг 2022.05.13-ны өдрийн 1/349 дугаар албан бичгээр УАГ-ын АНУЗГ-т хүргүүлэн ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын онцлог



"Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах" зорилтын хүрээнд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олонтой ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын сайн туршлагыг солилцон, чанарын хяналтыг хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг судалж, сайжруулах боломжтой асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН СИСТЕМ

Санхүүгийн тайлангийн аудитыг “Санхүүгийн тайлангийн аудитын систем FAS” ашиглан аудитын бүх үе шатны ажилбарыг гүйцэтгэн санхүүгийн тайлангийн аудитын статистик мэдээний үндсэн бааз суурь бий болсон.



Санхүүгийн тайлангийн аудитын системээр шалгагдагч байгууллагаас нэгдсэн судалгааг цахимаар нэгтгэсэн, мөн СТА-аар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгагдагч байгууллагын зүгээс цахимаар бэлтгэн аудиторуд хянан баталгаажуулсан үйл ажиллагаа нь аудитад хамрагдагч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлсэн, аудиторын ажлыг хөнгөвчилсэн, хэрэгжилтийн нотлох баримтын цахим сан үүсгэсэн дэвшилтэт алхам болов.

Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө



Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу 2022 онд төвлөрөх 3,361.4 сая төгрөгийн орлогыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 17 дугаар зүйлд заасны дагуу “Орон нутгийн сан” -д төвлөрүүлэн зарцуулж байх зөвлөмжийг Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар хүргүүлснээр тус орлогыг орон нутгийн орлогын төсвийн орлого болох аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгон аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2023 оны төсөвт оруулан баталсан.



COVID-19
Vaccines

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах ковидыг санхүүжилтийн 3,571.1 сая төгрөгийн авлагыг тайлант хугацаанд нь бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажилласнаар "Аудитын үр өгөөж тооцох журам"-ын 6.1.6 дахь заалтын дагуу зөвлөмжөөс үр өгөөжөөр тооцов.

Завсрын аудитын талаар



МУЕА-ын 2022.10.06-ны өдрийн А/75 дугаар "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" тушаалаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023 онд 268 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж 138 байгууллагад дүгнэлт гаргах, 130 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийхээр баталсан.



Батлагдсан хуваарийг үндэслэн 2022 оны санхүүгийн тайлангийн завсар үеийн аудитыг 2022.09.15-ээс эхлэн завсрын аудитын төлөвлөгөө, томилолтоор ажиллах удирдамжийн дагуу гүйцэтгэн ТШЗ-ийн санал дүгнэлт өгөх 17 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7, үе шатны ажлыг хэсэгчлэн түүвэрт хамруулах 69 нийт 93 байгууллагад хийлээ.



СТА-ыг хийлгэхээр гэрээ байгуулсан ХАК-ийн гүйцэтгэсэн 20 байгууллагын төлөвлөгөөг баталгаажуулан Санхүүгийн тайлангийн систем FAS-д үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Тайлант хугацаанд Нэгдсэн удирдамжаар 4 гүйцэтгэлийн аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 172 байгууллагыг хамруулан 170,4 сая төгрөгийн өртгөөр давхардсан тоогоор 21 аудитор 160 өдөр, 752 хүн/өдөр, 418 илүү цаг ажиллан аудитыг гүйцэтгэв.

01

Нэгдсэн удирдамжаар

Нийт 18,374.4 сая төгрөгийн 148 алдаа, зөрчил



3.1. Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудит

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар аудитыг 5 аудитор 30 өдөр, 120 хүн/өдөр, 60 илүү цаг ажиллан 68 байгууллагыг хамруулан шалгаж, АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу гүйцэтгэн дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.04.29-ны өдрийн А/11 тоот тушаалаар тушаалаар баталгаажуулан ҮАГ, Баянхонгор аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсэн.

- Аудитаар нийт 8,147.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1,455.4 сая төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6,687.0 сая төгрөгийн 14 зөвлөмж өгснөөс 933.7 сая төгрөгийн 14 албан шаардлага, 4,425.6 сая төгрөгийн 13 зөвлөмжийн биелэлт хангагдсан ба 2261.4 сая төгрөгийн 1 зөвлөмжийн хугацаа болоогүй байна.
- Аудитаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,476.1 сая төгрөгийн 7 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан.
- Аудитын тайланг 2022.04.29-ны өдөр 1/329 тоот албан бичгээр ҮАГ-ын ГНАГ-т, 1/330 тоот албан бичгээр Нийслэл дэх ТАГ-т, 1/331 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад, 1/332 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д тус тус хүргүүлэн байгууллагын цахим хуудаст тайланг байршуулан, инфографикийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн.

Аудитын үр нөлөө

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 2021 онд хэрэгжиж дуусахаар туссан төсөл, арга хэмжээ бүрэн дуусгуулж хүлээн авах талаар зөвлөмж өгч, аймгийн төвд спорт цогцолбор, усан бассейны дутуу ажлын 1,881.6 сая, Гурван булаг сумын сургуулийн барилгын ажлын 561.2 сая төгрөгийн дутуу ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан.
- Төсөл, арга хэмжээнд нийт 1,161.3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон зөрчилд албан шаардлага өгч барилгын дутуу ажлыг гүйцэтгүүлсэн.
- Зураг төсвийн дагуу хийгээгүй зарим ажлыг дахин гүйцэтгүүлснээс гадна, ашиглалтын явцад шаардлага хангаагүй 4 төсөл, арга хэмжээнд зөрчлийг арилгах албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан.



Дээрх QR кодоор тайлантай танилцана уу.


3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудит:

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудиторын 2022.02.15-ны өдрийн 01/207 дугаар албан бичгээр өгсөн чиглэл, удирдамжийн дагуу тус аудитыг орон нутгийн төрийн аудитын газрын ажилтнуудыг чадавхжуул зорилгоор манай байгууллага гүйцэтгэсэн нь орон нутгийн хувьд улсын хэмжээнд тайланг нэгтгэсэн анхны тохиолдол байсан ба аудитыг хянан удирдах 2, ахлах аудитор 2, аудитор 2, нийт 6 ажилтан 66 өдөр, 362 хүн/өдөр, 260 илүү цаг ажиллав.


А.Нэгдсэн тайлан

- Нэгдсэн тайлан, хураангуй тайлангийн төсөл, нэгдсэн судалгаанд ЯАГ-ын холбогдох албан хаагчдаар хяналт хийлгэн, 2022.11.01-ний өдөр ЯАГ-ын Удирдлагын зөвлөлд тайланг танилцуулан, МУЕА болон гишүүдээс гаргасан саналын дагуу хөрөнгийг НББ-д тусгасан эсэх талаарх нэмэлт судалгааг хийж, гишүүдийн саналын дагуу тайланг засварлан, ЧБА-аар чанарын хяналтыг хийлгэлээ.
- АНТАГ-ын хэмжээнд нийт 101,505.2 сая төгрөгийн 1163 зөрчил илэрснээс 621.3 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 67,846.6 сая төгрөгийн зөрчилд 530 албан шаардлага өгч, 33,037.3 сая төгрөгийн зөрчилд 572 зөвлөмжийг хүргүүлсэн үр дүн гарсан бөгөөд АНТАГ-уудын статистик мэдээнд тусгагдсан тул тус газрын статистик мэдээний тайланд давхардуулан оруулаагүй болно..
- Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Нэгдсэн тайлангаар нийт 9 зөвлөмжийг өгснөөс Монгол Улсын Засгийн газарт 1, Сангийн яаманд 3, аймаг, сум, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт 1, аймаг, сум, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт 4 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна. Нэгдсэн тайлангаар өгсөн зөвлөмж тус газрын статистик мэдээний тайланд тусгагдсан.
- Аудитын тайланг МУЕА-ын 2022.12.09-ний өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан ба тушаалд заасны дагуу тайланг түгээх, хүргэж ажлыг АНУЗГ хариуцан ажиллаж байна. ЯАГ-ын Тамгын газрын 2022.12.12-ны өдрийн 02/1568 дугаар албан бичгийн дагуу АНТАГ-ыг үнэлэн ЯАГ-т хүргүүллээ.

Аймаг, нийслэлийн ОНХС-ийн 2021 оны төлөвлөгөө, гүйцэтгэл/тэрбум төгрөгөөр/



“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН”-нд хийсэн аудитын үр дүн/тэрбум төгрөгөөр/



Аудитын үр нөлөө

- Сангийн сайдын 2022.11.25 01/8031 тоот албан бичгээр өгсөн Орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.3 дахь заалтыг анхаарч ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системд 2019-2022 оны мэдээллийг бүрэн оруулж, 2023 оны мэдээллийг цаг тухайд нь оруулж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахыг анхааруулсан чиглэл өгсөн байна.

Б.Баянхонгор аймгийн ОНХС

- Аудитаар нийт 5,860.8 сая төгрөгийн 63 зөрчил илэрснээс 43.8 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 4,490.6 сая төгрөгийн 45 албан шаардлага, 4 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,321.9 сая төгрөгийн 7 зөвлөмж өгснөөс 38.5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 4,391.0 сая төгрөгийн 44 албан шаардлага, 1,321.9 сая төгрөгийн 7 зөвлөмжийн биелэлт хангагдсан.
- Аудитаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,665.7 сая төгрөгийн 30 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан.

Аудитын үр нөлөө

- Гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүй 2,907.5 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дуусах санхүүжилт авсан зөрчилд албан шаардлага өгч ажлыг байнгын ашиглалтад оруулсан.
- ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 709.8 сая төгрөгийн 9 ажлыг ашиглалтад оруулах албан шаардлага өгч биелэлтийг хангуулснаар хөрөнгийн үр өгөөж гарч эхэлсэн.
- Иргэд ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой тайлан, мэдээллийг Удирдлагын мэдээллийн системээс дамжуулан бүрэн авах нөхцөл бүрдсэн.

3.3. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудитыг 2022.04.01-ээс 2020.05.05-ны хооронд 4 хүн 25 өдөр, 75 хүн/өдөр, 20 илүү цаг ажиллаж 6 байгууллагыг хамруулан 2016-2021 оныг үйл ажиллагааг шалгав.

- Аудитаар нийт 261.6 сая төгрөгийн 16 зөрчил илрүүлж, 10.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 251.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, албан шаардлагыг биелүүлж ажилласан талаарх албан бичгийг хүлээн авч хэрэгжилтийг тооцон ажиллав.
- Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторын 2022.05.03-ны өдрийн А/12 тоот тушаалаар баталгаажуулан 2022.05.04-ний өдрийн 1/338 тоот албан бичгээр ҮАГ-ын АГГ, 339 тоот албан бичгээр аймгийн Засаг дарга, 1/340 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын дарга, 1/341 тоот албан бичгээр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлсэн ба аудитын тайлан, инфографикийг байгууллагын цахим хуудас, фейсбүүк хаягт байршуулсан.

Аудитын үр нөлөө

- Аймгийн ЗДТГ-ын захиалгаар Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар нь Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилго бүхий “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа”-тай болсон.



Дээрх QR кодоор
тайлантай танилцана уу.

3.4. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” -т хийсэн гүйцэтгэлийн аудит;

Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” аудитын дэд төлөвлөгөөг газрын дарга, тэргүүлэх аудитораар 2022.05.06-ны өдөр батлуулж, хянан удирдах 2, гүйцэтгэх 4 нийт 6 хүн 39 өдөр, 195 хүн/өдөр, 78 илүү цаг ажиллан аудитыг гүйцэтгэв.

- Аудитаар төрийн өмчит, орон нутгийн өмчит хуулийн этгээдээр хоёр тайланг бэлтгэж аудитын менежерээр хянуулан газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.06.29 өдрийн А/19 дугаар тушаалаар баталгаажуулан тайланг ҮАГ-ын ГНАГ-т 2022.06.30-ын өдөр 1/394 дугаарт албан бичгээр, аймгийн ИТХ-д 1/395 дугаарт албан бичгээр, Засаг даргад 1/396 дугаарт албан бичгээр, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд тус тус хүргүүлсэн.
- Аудитаар нийт 4,105.1 сая төгрөгийн 33 алдаа, зөрчил илрүүлж 45.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 302.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага, 3,756.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 20 зөвлөмжийг хүргүүлсэн. Аудитаар 231.8 сая төгрөгийн 4 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрч бүртгэв.
- Шийдвэрийн хэрэгжилт 36.1 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж, 302.9 сая төгрөгийн 8 албан шаардлагын зөрчлийг арилгаж, 3,700.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан ба шийдвэрийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитын үр нөлөө

- “Чандмань Баянхонгор” ХК -ийн хөрөнгөд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглалтгүй байгаа Хонгор-1000 хорооллын 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн үр ашгийг гаргаж эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсний үр дүнд аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 10/41 тоот тогтоолоор “Чандмань-Баянхонгор” ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Хонгор 1000” дулаан үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зарим хөрөнгийг 2,031.4 сая төгрөгөөр хувьчлах шийдвэр гарсан.
- “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн засаглалыг сайжруулснаар орон нутгийн төсвөөс жил бүр 50-100.0 сая төгрөгийн дэмжлэг авдаг байсныг зогсоож 2023 оны төсвийн төсөлд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-д олгох санхүүгийн дэмжлэг батлагдаагүй болно.
- Сум орон нутагт хууль зөрчин үр ашиггүй орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж уул уурхай эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс орсон хандивын орлогыг төвлөрүүлэн зарцуулдаг байдлыг таслан зогсоох зөвлөмж хүргүүлсний үр дүнд Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний алба УТҮГ-ыг татан буулгаж уул уурхай эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс орсон хандивын орлогыг сумын ОНХС-ийн эх үүсвэрт оруулахаар болсон.



Дээрх QR кодоор
тайлантай танилцана уу.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ;

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/34 “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” тушаалаар Орон нутгийн нөхөн сонгуулийн хийхтэй холбоотойгоор нийцлийн 3 аудит нэмэгдсэн. Тус аудитыг 22,3 сая төгрөгийн өртгөөр 5 хүн 33 өдөр 10 цаг илүү ажиллан гүйцэтгэв.

4.1. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох 2 намын мөрийн хөтөлбөр, хандивын тайланг хүлээн авч 2 хүн 17 өдөр ажиллав.

- Сонгуульд оролцох намуудын мөрийн хөтөлбөр, хандивын тайланг хянан дүгнэлтийг дээрх 2 нам болон Өлзийт сумын Сонгуулийн хороонд 1/306 тоот, Өлзийт сумын Ардчилсан намын хороонд 1/304, 1/307, Өлзийт сумын Монгол ардын намын хороонд 1/303, 1/308 тоот албан бичгээр тус тус 2022.04.18-ны өдөр хүргүүлсэн.
- Аудитын дүгнэлтийг цахим хуудаст сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт, намуудын мөрийн хөтөлбөрийг хуулийн хугацаанд буюу 2022.05.28-ны өдөр байршуулсан.

4.2. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянах, нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг газрын дарга, тэргүүлэх аудиторар 2022.07.18-ны өдөр батлуулан, хянан удирдах 2, ахлах аудитор 1 нийт 3 хүн 11 өдөр ажиллан гүйцэтгэлээ.

- Аудитаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн орон нутгийн ээлжит бус, нөхөн сонгуулиар Баянхонгор аймгийн Өлзийт суманд Монгол ардын нам болон Ардчилсан намаас нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, аудитын тайланг газрын дарга тэргүүлэх аудиторын 2022.09.14-ны өдрийн А/23 тоот тушаалаар баталгаажуулан 2022.09.16-ны өдөр www.audit.mn цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлсэн.

4.3. Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудит

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай 10 дүгээр зүйлийн 10.8 хэсэгт заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлсэн Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Аудитыг 1 аудитор 2022.07.05-2022.07.18-ны хооронд 5 өдөр 10 илүү цаг ажилласан гүйцэтгэв.

- Аудитын тайланг газрын дарга Тэргүүлэх аудиторын 2022.07.18-ы өдрийн А/21 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн. аудитаар нийт 0.5 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан.

ТАВДУГААР БҮЛЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ



Тайлант онд аймгийн ИТХ-ын захиалгаар 2 аудитыг 41,9 сая төгрөгийн өртгөөр нийт 9 хүн 106 өдөр, 346 хүн/өдөр, 126 илүү цаг ажиллан гүйцэтгэж 11.2 сая төгрөгийн 2 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажилласан бөгөөд зөвлөмжөөс бий болох үр өгөөжийн хэрэгжилтийн үр нөлөө гарах хугацаа хүлээгдэж байна.



Аймгийн ИТХ-ын захиалгаар



5.1. Баянхонгор аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Баянхонгор аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналын дагуу гүйцэтгэлийн аудитыг хянан удирдах 2, аудитор 2 нийт 4 хүн 73 өдөр, 216 хүн/өдөр, 66 илүү цаг ажиллаж, 11 байгууллагын хамруулан, аймгийн ИТХ-аар 2016-2020 онд баталсан 34 дэд хөтөлбөрийг хамруулан шалгав.

- Аудитын тайланг Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.11.18-ны өдрийн А/33 дугаар тушаалаар баталгаажуулан 2022.11.21-ний өдөр аймгийн ИТХ-д 1/510 тоот, аймгийн Засаг даргад 1/509 тоот албан бичгээр тус тус хүргүүлэв.
- Тус аудитаар аймгийн ИТХ-д 2 асуудлыг толилуулан, аймгийн Засаг даргад 5, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргад 1 зөвлөмж өгөв.
- Гүйцэтгэлийн аудитын үр дүнг визуал хэлбэрээр иргэд олон нийтэд түгээн сурталчлан, байгууллагын цахим хуудас, фейсбүүк хуудаст байршуулсан. Зөвлөмжийг хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитын үр нөлөө

• Гүйцэтгэлийн аудитаар богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжиж дууссаны дараа эцсийн үр дүнг тооцож, аймгийн ИТХ-д тайлагнах зөвлөмжийг өгснөөр тус аудитын үр нөлөө гарсан байна.



Дээрх QR кодоор тайлантай танилцана үү.

5.2. Баянхонгор аймгийн орон нутгийн орлогод байгаль орчноос орж ирж байгаа хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүн /2020-2021/

Баянхонгор аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналын дагуу тухайн аудитыг 5 хүн 53 өдөр, 130 хүн/өдөр, 60 цаг илүү цагаар ажиллаж, 21 байгууллагын 2020, 2021 оны үйл ажиллагааг

хамруулан шалгаж, дарга, тэргүүлэх аудиторын 2022.10.10-ны өдрийн А/27 дугаар тушаалаар гүйцэтгэлийн тайланг баталгаажуулсан.

- Тайланг 2022.10.12-ны өдөр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 1/432 тоот, Баянхонгор аймгийн Засаг даргад 1/433 тоот, аймгийн ИТХ-д 1/434 тоот, аймгийн БОАЖГ-т 1/435 тоот, Бөөнцагаан-Орог нуурын сав газарт 1/436 тоот, Баянхонгор аймгийн Татварын хэлтэст 1/437 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.
- Аудитаар нийт 1,487.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,483.6 сая төгрөгийн 15 зөвлөмж өгснөөс 3 албан шаардлагыг биелүүлэн ажилласан бол зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.
- Аудитаар 130.1 сая төгрөгийн 7 үр өгөөжийг бүртгэж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 11.2 сая төгрөгийн 2 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан.

Аудитын үр нөлөө

- Ус ашиглах дүгнэлтийн дагуу дутуу төвлөрүүлсэн татвар болон дүгнэлт гаргуулаагүй ус ашиглагч нарын төлбөрийн орлого 11.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас төсвийн алдагдал нөхдөг байдлыг зогсоож, зориулалтын дагуу баталж, зарцуулах боломж бүрдсэн.
- Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хийсэн “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-г олон нийтэд ил тод болгосон.



Дээрх QR кодоор тайлантай танилцана уу.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ

СУРГАЛТЫН ТАЛААР:

Төрийн аудитын байгууллагын 2022 онд дэвшүүлсэн "Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах" зорилтын аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор ТАБ-аас болон байгууллагын дотоод сургалтаар 5 чиглэлээр 26 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан Газрын дарга, тэргүүлэх аудитораар 2022.01.25-ны өдөр батлуулж хэрэгжилтийг сургалтын хяналтын самбар дээр хугацаагаар нь хэрэгжилтийг тооцон ажиллав.


ТАБ-ын нэгдсэн сургалтын төлөвлөгөө болон байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан 5 зорилтын хүрээнд 44 удаагийн сургалт, хэлэлцүүлгээр 549 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Үүнд:

- УАГ-аас зохион байгуулсан 24 сургалтад давхардсан тоогоор 196 албан хаагч
- Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 сургалтад давхардсан тоогоор 333 албан хаагч (Төрийн аудитын газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан Төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудыг оруулан тооцсон тоо)
- Бусад байгууллагаас зохион байгуулсан 8 сургалтад 20 албан хаагч тус тус оролцсон байна.

Онцлох сургалтууд:

- “Нэгдсэн сургалт-2022”-д бүх албан хаагч, Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн системээр зохион байгуулагдсан 5 удаагийн сургалтад 18 албан хаагч хамрагдан, явцын болон эцсийн сорил шалгалтад амжилттай үнэлгээ авч сертификаттай албан хаагчдын тоо 29-аар нэмэгдсэн.

- Тус нэгдсэн сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь багш, чиглүүлэгчээр оролцож ОНХС-ын нэгдсэн удирдамжтай аудитын хэлэлцүүлгийг сургалтын 6 бүлэгт зохион байгуулсан.
- Аудитын чанарын хяналтыг дээшлүүлэх 5 удаагийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, Архангай, Говь-Алтай аймаг дахь ТАГ-тай аудитын чанарыг хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа арга барилыг ажлын талбар дээр нь харилцан танилцаж хэлэлцүүлэг хийн сайн туршлагаудаа хуваалцсан.
- Төрийн аудитор ёс зүй, хувь хүний хөгжлийн сургалтуудаар өөрийгөө хөгжүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гэр бүл болон ажлын хамт олон, хамтран ажиллагч байгууллагын хүмүүстэй хэрхэн зөв эерэг хандлагаар хандах, хараат бус байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх арга зүйгээс суралцсан.
- Дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “ТАБ-ын нэгдсэн сургалтын төлөвлөгөөний шинэ тушаал, журмаар хичээл хийх” сэдвийн хүрээнд МУЕА-ын 2022.06.24-ны А/54 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам", 2022.07.19-ны А/59 тушаалаар баталсан "Төрийн хэмнэлийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл" журмаар нийт ажилтнуудад 2022.07.29-ний болон 2022.10.04-ны өдрүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Байгууллагын сургалтын 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт 2022.12.14-ны өдрийн 1/655 дугаар албан бичгээр цахим шуудангаар хүргүүлсэн.



Хамтын ажиллагаа, олон нийт

Баянхонгор аймаг Төрийн аудитын газар нь “Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцооны стратеги”, “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ийн 2022 онд хэрэгжүүлэх дэд төлөвлөгөө гарган нийт 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллав. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын захиалгат аудитыг гүйцэтгэх, аймгийн Засаг даргын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх, Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах дүн шинжилгээний аудитыг гүйцэтгэхэд хамтран ажиллалаа.
- Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяаны байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн дүгнэлт, илэрсэн зөрчил болон Орон нутгийн 2023 оны Төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийг аймгийн ИТХ-ын Эдийн засгийн хороогоор оруулан хэлэлцүүлэв.
- Аудитын илэрсэн зөрчлийг барагдуулах, хууль эрх зүйнд нийцсэн аудитын шийдвэрийг гаргахад зөвлөгөө тусламж авах, төр учирсан хохирлыг барагдуулахад хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ”-ийг аймгийн Прокурорын газрын Ерөнхий Прокурортой Газрын дарга, тэргүүлэх аудитор 2022.04.28-нд байгуулан ажиллалаа. Мөн Төр учирсан хохирлын барагдуулалтыг олон нийтэд мэдээлэх талаар “АМЬД ХУУЛЬ ТӨВ” ТББ -тай хамтран ажиллаж мэдээллээр хангаж ажилласан.
- Санхүү, гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнгийн тухай танилцуулга, зөвлөмж бэлтгэж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт албан бичгээр хүргүүлэв.
- Төрийн аудитын газрын үйл ажиллагааг сурталчлах, аудитын дүн дүгнэлтийг олон нийтэд хүргэхээр “Өнөөгийн Баянхонгор” сонин, “Номгон ТВ” зэрэг орон нутгийн хэвлэлийн

байгууллагуудтай гэрээ байгуулан Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл аудитын 4 мэдээллийг нийтлүүлж, нэвтрүүлсэн.

- Дижитал - Баянхонгор арга хэмжээний хүрээнд 2022.06.15-ны өдөр нээлттэй хаалганы өдөрлөг (танилцуулга, шторк, гарын авлага бэлтгэн 300ш тараав.) зохион байгуулан WWW.OPENAUDIT.MN цахим хуудсаар дамжуулан иргэд Төрийн хяналтын үйл ажиллагаанд хэрхэн оролцох сурталчилж, гарын авлага тараав.
- Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд 100 дугуйчин 100 км “Бөмбөгөр-100” гэсэн аяллын арга хэмжээг аймгийн Дугуйн холбоотой хамтран зохион байгуулав. (дугуйчид амрах 5 өртөөний 1-г байгуулан дугуйчид болон бөмбөгөр сумын ард иргэдэд танилцуулга, гарын авлага 200 ш тараав.).
- “Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн танилцуулга”, “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”-гийн талаар 2 шторк олон нийтэд түгээсэн.





Санхүү, гүйцэтгэл, нийлцийн аудитын 8 тайланг инфографик цахим ном /визуал/ хэлбэрээр audit.mn болон facebook хуудсаар, Төрийн аудитын байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон цаг үеийн ажилтай холбоотой 144 мэдээллийг тухай бүр олон нийтийн сүлжээгээр хүргэн ажилласан. Төрийн аудитын байгууллагын 100 жилийн түүх ой хүрээнд хийгдсэн нэвтрүүлэг, танилцуулгыг олон нийтийн сүлжээнд facebook хуудсаар болон олон нийтийн дүрст самбараар мэдээлсэн.



Төрийн аудитын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд 2022 оны 10 дугаар сард аймгийн санхүү бүртгэлийн ажилтнуудын дунд онол практикийн бага хурал зохион байгуулж “Төрийн санхүү, төсвийн хяналтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт сэдэвт илтгэлийн уралдаан хэлэлцүүлгийг зохион байгуулан 3 илтгэлийг шилдгээр шалгаруулан, шинэ санаа, асуудлыг ажилдаа нэвтрүүлж ажиллах зөвлөмжийг гаргалаа.

Цахим системийн үйл ажиллагаа

Санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системд 264 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын үе шатны бүх ажлыг журмын дагуу оруулан баталгаажуулж аудитыг гүйцэтгэсэн.

- СТА-ийн статистик мэдээг Fas.audit.mn дэлгэрэнгүй тайлантай 2022.09.15-нд тулгалт хийж зөрүү гараагүй болохыг МТТ-д мэдэгдсэн. Санхүүгийн аудитын FAS системд шийдвэрийн хэрэгжилтийг оруулсан. Тус системийг ашиглан аудитын илрүүлэлтийн статистик мэдээг 100 хувь алдаа, зөрчилгүй нэгтгэл дүнг авч төрөл бүрээр ангилан шүүлт хийж ашиглаж үр дүнгээ өгч байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын perf.audit.mn системийг ашиглан Баянхонгор аймгийн хэмжээнд эрх шилжин ирсэн 64,608.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27,153.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 34 төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулсан. Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг local.audit.mn цахим системээр нэгтгэж байна.
- Мөн able.audit.mn программын "албан бичиг" цэсийг ашиглан албан хэрэг хөтлөлтийг хөтөлж, "Ажил хэрэг" цэсийг ашиглан аудитын хөтөлбөр болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, "Цаг бүртгэл" цэсийг ашиглан албан хаагчдын цагийг бүртгэж, "Захидал", "Олон нийт" болон Able чатыг ашиглан дотоод болон гадаад цахим хэрэглэгч нартай харилцаж байна. Able системийн цаг бүртгэлийн системийг ашиглан ажлын цаг ашиглалтыг бүртгэж цагийн тайланг гарган ажилласан.
- Үндэсний аудитын газарт шууд тайлагнах аудитын мэдээг 14 хоног тутамд ажлын явцыг data.audit.mn системээр дамжуулан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг [woord](http://woord.audit.mn) болон PDF болгон байршуулж явцын мэдээллийг шинэчлэн тайлагнан ажиллав.
- Албан хаагчдад сургалтын үйл ажиллагааны хүрээнд surgalt.audit.mn систем ашиглан сургалтад хамрагдаж, явцын болон эцсийн сорилыг цахимаар өгөв.
- Олон нийтэл ил тод мэдээлэх зорилгоор аудит audit.mn болон open.audit.mn сайтуудаар мэдээлэл түгээхээс гадна google-form систем системээр олон нийтээс аудитын сэдвийн санал, аудитын хүрээнд авах санал асуулга зэргийг авсан.
- Аудитын өдөр тутмын үйл ажиллагаанд egr.e-mongolia.mn google-drive, Teams, зэрэг програмуудыг ашиглан судалгаа, тайлан, үүрэг даалгаврын хэрэгжилт зэргийг нэгтгэж ажилласан.

Авлига, ашиг сонирхол, ёс зүй, ХАСХОМ

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23

дугаар зүйлд заасны дагуу албан 2021 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд буюу 2022.01.17-ны өдөр гаргаж мэдээллийг ХАСХОМ-ын бүрдүүлэлтийн системд бүрэн оруулж баталгаажуулсан. Тайланг хоцроосон, мэдээлээгүй албан хаагч байхгүй, тайланг албажуулан 2022.01.21-ний өдөр ҮАГ-т хүргүүлсэн.

- "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө"-нд 11 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж хэрэгжилтийг ханган биелэлтийг ҮАГ-ын ЗХЭЗГ, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст албан бичгээр хүргүүлж ажиллав.
- Баянхонгор аймгийн Засаг даргын баталсан "Авлигын эсрэг манлайлал" болзолт уралдааны дагуу ажлын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сард гарган хэрэгжүүлэн ажиллаж ажлын тайланг 2022.11.28-ны өдөр 1/520 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-т хүргүүлэн, аймгийн хэмжээнд 3 дугаар байрт шалгарсан байна.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай 3 ажилтны мэдэгдлийг холбогдох эрх бүхий албан тушаалтнаар шийдвэрлүүлэн байгууллагын шилэн данс, <https://meduuleg.iaac.mn>-д тухай бүр нь мэдээлж ажиллалаа.
- Тайлант онд тус газрын албан тушаалтнууд Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажилласан.

Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Төрийн байгууллага нь төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ҮАГ-ын Захиргаа, удирдлагын хэлтэст 2022.01.19-ний өдөр 1/40, Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст 1/39 дүгээр албан бичгээр хүргүүлж ажиллав.

- Тайланд онд гадаад улсад хувийн зорилгоор зорчсон нэг албан хаагчийн судалгааг 1/660 дугаар албан бичгээр 2022.12.14-ний өдөр Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагад ашиглаж байгаа лацны бүртгэлийг тухай бүр нь шинэчлэн албажуулж, хадгаламжийн нэгж болгон, байгууллагын архивд шилжүүлсэн.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг албан бичгээр тухай бүр хүргүүлж ажилласан.


Архив, бичиг хэргийн хөтлөлт

Байгууллагын Баримт нягтлан шалгах комисс 2022 онд 7 ажлыг төлөвлөн хэрэгжилтийн тайланг ҮАГ-ын ЗХЭЗГ-т 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 1/657 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан 13 ажил хийхээр төлөвлөж хэрэгжилтийг ТАГ-ын БНШК-т тайлагнасан.

- Байгууллагын БНШК нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан бичиг хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", МУЕА-ын 2022.06.24-ны өдрийн А/54 тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам", Монгол улсын стандарт MNS 5140-1,2,3 2021-ыг мөрдөн ажилласан эсэхэд 2 удаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хэвлэмэл хуудасны зарцуулалтад 2022 оны 4,6,8 дугаар сард шалгалт хийж дүнг дарга, тэргүүлэх аудиторт танилцуулан ажилтнуудад зөвлөгөө өгч биелэлтийг тооцон арга зүйн удирдлагаар хангасан.
- Байгууллагын архивд хадгалагдаж байгааг 1995-2018 он хүртэл аудитын тайлан, шалгалтын материалыг Төрийн архивын тасагт шилжүүлэх гэрээний дагуу 2018 оны санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл болон нийцлийн аудитын шалгалтын материал болох 294

хадгаламжийн нэгж (46320 хуудас) баримтыг 2022.01.27-ны өдөр хүлээлгэн өгч цахимд оруулсан. Энэ нь байгууллагын архивын даацыг бууруулж чадсан үр дүнтэй ажил арга хэмжээ болж байгаа.

- Цахим - Баянхонгор хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 2019 оны байнга хадгалах 38 хадгаламжийн нэгж баримтыг Төрийн архивын тасагт цаасаар болон дансны хамт цахимд оруулан ашиглалтын хувь үүсгэн хүлээлгэн өгсөн.
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын 264 байгууллагын, гүйцэтгэлийн аудитын 7, нийцлийн аудитын 3 сэдвийн хүрээнд хийсэн аудитын материалыг ажилтнууд архивын нэгж болгон аудитын менежер, тэргүүлэх аудитор аар хянуулан цахим /pdf/ хэлбэрт шилжүүлэн нийт 352 хадгаламжийн нэгж баримтыг хүлээлгэн өгснийг байгууллагын архивд хүлээн авсан.
- Тайлант 2022.12.20-ны өдрөөр цахимаар 42, бусад байгууллага албан тушаалтнаас 679 нийт 721 албан бичгийг хүлээн авч, гаднын болон системийн байгууллагад 837 албан бичгийг төрийн албан хэрэг хөтлөлтийн Able программ, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын ERP нэгдсэн системд бүрэн бүртгэж, холбогдох албан тушаалтнуудад цахимаар шилжүүлэн хугацаанд нь шийдвэрлүүлж гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан.
- Тайлант хугацаанд албан бичгийн шийдвэрлэлт, хариутай бичгийн хугацаа хоцролт байхгүй болно.
- Газрын дарга, тэргүүлэх аудиторын А тушаал 39, Б тушаал 22 гарч хэрэгжилтийг ханган ажиллав.
- Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.12.01-ний өдрийн А/36 дугаар тушаалаар томилогдсон комисс байгууллагын албаны тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, албан хэвлэмэл хуудасны тооллогыг хийж дүн тайланг нэгтгэн илтгэх хуудас бичиж нотлох баримтын хамт танилцуулан тайланг Төрийн архивын тасагт 2022.12.07-ны өдрийн 1/628 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Архивын ажилтан нь архивын өрөөнд байвал зохих стандартын дагуу хяналт тавин ажиллав.



Зураг.1.Архивын өрөө камераар, нягтруулсан төмөр шүүгээ, бусад хэрэгсэл

Өргөдөл, гомдол

Тайлант онд МУЕА-т гаргасан ажлаас чөлөөлөгдөх 3, чөлөө хүссэн 1, сул ажлын байрын орох хүсэлтэй 5 өргөдлийг уламжилж хугацаанд нь шийдвэрлүүлж хариуг нь холбогдох хүмүүст өгсөн.

- Тэргүүлэх аудиторт ирүүлсэн ээлжийн амралтын хугацааг хойшлуулах хүсэлт гаргасан 2 албан хаагчийн өргөдлийг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэсэн. Өргөдлийн бүртгэлийг абле системээр хийж байгаа бөгөөд МУЕА-т шууд гаргасан 2 өргөдөл able системд ороогүй болно. Тайлан оны өргөдөл, гомдлын мэдээг абле системээс татан авч УАГ-ын Албан хэрэг хөтлөлт хариуцсан ахлах шинжээчид хүргүүлэн ажилласан.

Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг утгасан арга хэмжээ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон ТАБ-ын үүсэж хөгжсөний 100 жилийн ойг утгасан 10 ажил төлөвлөж 2021-2022 онд бүрэн хэрэгжүүлж ажилласан.



Тус газрын албан хаагчид Төрийн аудитын байгууллагын 100 жилийн ойд зориулсан “Төрийн аудитын хөгжил, цаашдын чиг хандлага” онол, практикийн бага хуралд “Санхүүгийн тайлангийн аудитын чиг хандлага” гэсэн сэдвээр илтгэл бичиж хүргүүлсэн. Улаанбаатар хотод 2022.08.24-26-нд зохион байгуулагдсан ТАБ-ын 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд хамт олноороо хүрэлцэн очиж оролцлоо.




ТАБ-ын 100 жил, Баянхонгор аймагт төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 50 жилийн ойг 2022.10.14-нд “Төрийн санхүү, төсвийн хяналтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” гэсэн сэдэвт олон практикийн бага хурал зохион байгуулан ахмад, дунд, залуу үеийн мэдлэг, туршлага солилцсон, шинэ мэдээллээр мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн арга хэлбэрээр зохион байгууллаа.



Баянхонгор аймгийн хяналтыг байгууллагын түүхийг харуулсан “ТӨРИЙН ХЯНАЛТ-ТҮМНИЙ ХЯНАЛТ” нэртэй номыг хэвлэн гаргасан.


ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүжилтийн орлого



Тайлант онд анх 499.3 сая төгрөгийн төсөв батлагдсан ба оны дундуур төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор дутагдалтай байгаа зардалд төсвийн зохицуулалт хийлгэж тайлант оны дундуур 516.7 сая төгрөг болсон нь бичиг хэргийн зардал 1.6 сая, шуудан холбооны зардал 0.6 сая, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 0.6 сая, урсгал засварын зардал 4.3 сая, албан томилолтын зардал 6.5 сая нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 0.4 сая, гэрээт ажилтны цалин 3.4 сая төгрөгөөр тус тус анхны батлагдсан төсвөөс нэмэгдсэнтэй холбоотой бол жилийн эцсийн байдлаар батлагдсан төсөв 479.3 сая болж 37.4 сая төгрөгөөр буурсан нь тайланд онд дутуу ажилласан орон тооны цалингийн хэмнэлтийг ҮАГ-аас татан шилжүүлсэнтэй холбоотой байна

Зардлын зарцуулалт



Батлагдсан төсвийг зардлын бүлэг тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан ба 2022.12.22-ны байдлаар 462.3 сая төгрөгийг зардлын гүйцэтгэл гарч 17 сая төгрөгийг төвлөрүүлж 96.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсөвт зардлыг хэмнэлт нь 2022 оны хагас жилээс хойш орон тоо дутуу ажилласантай холбоотой болно.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого



Нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банк дахь 100030024401 тоот дансанд 31.8 сая төгрөгт төвлөрснөөс тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төлбөрт нөхөн төлбөрт 0.4 сая, хувийн аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын төлбөрт 20,9 төгрөгийг зарцуулж 2022.12.23-ны байдлаар 10.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн мэдээ тайлан

Байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг Мишээл Од ХХК-аар хийлгэн “Зөрчилгүй санал” дүгнэлтийг авсан болно.

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, НДШ-н НД7,8 мэдээ сар бүр, татварын тайланг улирал бүр гаран холбогдох байгууллагад нь, санхүүгийн эхний хагас жилийн тайланг гаргаж ҮАГ-т цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.
- Байгууллагын хөрөнгийн 2022 оны эхний хагас жилийн тооллогыг Дарга, Тэргүүлэх аудиторын 2022.05.23-ны өдрийн А/14 тоот тушаалаар Тооллогын комисс томилогдон 05 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн ба төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллоготой холбоотой ТӨБЗГ-ын <http://pcsp.gov.mn/> системд байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тооллогын программд холбогдох мэдээллийг бүрэн шивж оруулсан.
- Баянхонгор аймагт ажиллаж байгаа ТӨБЗГ болон аймгийн ОНӨГ-аас томилогдсон хяналтын тооллогын комисс 2022.06.22-ны өдөр байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналтын тооллого хийж, хадгалалт хамгаалалт, бүртгэл тооцоо, байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа тайлан мэдээнд үнэлэлт дүгнэлтийг хийж ТӨБЗГ-тай хийсэн “Өмч эзэмшлийн гэрээ”-г дүгнэсэн ба манай байгууллага 96 хувьтай буюу “хангалттай сайн” үнэлэгдэж гэрээгээ сунган ажилласан болно.
- Байгууллагын өмч хамгаалах салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ҮАГ-ын Өмч хамгаалах зөвлөлд 2022.12.14-ны өдрийн 1/656 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/37 тоот тушаалын дагуу 2022.12.23-25-ны хооронд хийж гүйцэтгэн тооллогын дүнг байгууллагын ӨХСЗ-өөр хэлэлцүүлэн Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.12.23-ны өдрийн А/39 тоот тушаалаар баталгаажуулсан.
- ТАГ-ын 2022 оны төсвийн төслийг боловсруулж ҮАГ-т 2022.05.24-ний өдрийн 1/356 тоот албан бичгээр, 2022 оны хуваарийн өөрчлөлт оруулах саналыг тухай бүр ҮАГ-т хүргүүлснээр төсвийн хуваарь өөрчлөлт орж жилийн эцэст төсөвт зардлын өр авлагагүй ажилласан.

Шилэн дансны мэдээллийн талаар



Шилэн дансны портал сайтад бүтэн жилээр байршуулах 11 төрлийн 11 мэдээ, хагас жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээ, улирал бүр байршуулах 4 төрлийн 4 мэдээ, сар бүр байршуулах 3 төрлийн 36 мэдээ, тухай бүр байршуулах 8 төрөл 96, нийт 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан.